



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10 (147)

Монгол Улсын Засгийн газрын тогтоол:

- *“Улсын сайн талчин” тэмдгийн тухай*
- *Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай*
- *Иргэний үнэмлэх төлбөргүй олгох тухай*
- *Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн элнэлэг байгуулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

**Улаанбаатар хот
2000 он**



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2000 оны гуравдугаар сарын 20 № 10 (147)

Гарчиг

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг

130. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 28	209
131. Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай	Дугаар 29	210
Хоёр. Монгол Улсын Засгийн газрын тогтоол		
132. Хөтөлбөр батлах тухай	Дугаар 229	210
133. "Улсын сайн малчин" тэмдгийн тухай	Дугаар 1	221
134. Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай	Дугаар 2	221
135. Төсөв захиран зарцуулах эрхийн тухай	Дугаар 6	222
136. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон" шалгаруулах тухай	Дугаар 8	223
137. Иргэний үнэмлэх төлбөргүй олгох тухай	Дугаар 9	223
138. Хуулийн биелэлтийг зохион байгуулж хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 10	223
139. Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг байгуулах тухай	Дугаар 13	225
140. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зарим байгууллагын санхүүжилтийн тухай	Дугаар 14	226
141. Журам, гэрчилгээний маягт батлах тухай (Байгаль орчны сайдын 2000-1-7-ны тушаал)	Дугаар 5	227

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөр шатны шүүхэд шилжин ажиллах болсонтой холбогдуулан Дансрангийн Наранцэцэгийг Архангай аймгийн шүүхийн шүүгчийн, Ламгивийн Борыг Баянхонгор

аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Базаргарьдийн Сүхгомбыг Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2000 оны 3 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Ламгивийн Борыг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, Базаргарьдийн Сүхгомбыг Хэнтий аймгийн шүүхийн шүүгчийн, Каманы Зулхашийг Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Амгалангийн Насандэлгэрийг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Намсрайн Нарангэрэлийг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Хумбаагийн Отгонжаргалыг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Дашдэлэгийн Ганзориг, Пунцагийн Цэцэгдулам, Лодойн Цэрэндулам нарыг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Далайн Энхбаатарыг нийслэлийн Багануур дүүргийн

шүүхийн шүүгчийн, Самбуугийн Оюунчимэг, Дашцоодолын Дэлгэрцэцэг, Хуушааны Эрдэнэсүвд нарыг нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, Пунцагийн Золзаяа, Сумьяагийн Пүрэвсүрэн нарыг нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн, Лхагвагийн Нинжбатыг нийслэлийн Сонгинохайран дүүргийн шүүхийн шүүгчийн, Сайнбаярын Базарханд, Батаагийн Батцэрэн нарыг нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн, Гарамжавын Буянжаргалыг нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчийн, Равдандоржийн Алтантуяа, Готовдоржийн Цагаанцоож, Дансрангийн Наранцэцэг нарыг нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1999 оны 12 дугаар
сарын 29-ний өдөр

Дугаар 229

Улаанбаатар
хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр" -ийг 1 дүгээр, уг хөтөлбөрийг 2000-2005 онд хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг 2 дугаар, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавих зөвлөлийн бүрэлдхүүнийг 5 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хагас жил дутам засгийн газарт танилцуулж байхыг тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион

байгуулж, хяналт тавих зөвлөлийн дарга Н.Батбаярт даалгасугай.

3. Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн дэргэд насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх (орон тооны бус) зөвлөл байгуулах асуудлыг 2000 оны 1 улиралд багтаан шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүйн сайд Д. Ганболдод үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД**

Р.АМАРЖАРГАЛ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Д.ГАНБОЛД

ХҮҮХДИЙН БОЛОН ТҮҮНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг.Хөтөлбөрийн үндэслэл

1.Монгол орны ирээдүй болох хүүхдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах нь чухал асуудал болоод байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах талаархи хууль тогтоомжийг биелүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих ажил суларснаас хүүхдийн эрх ашиг сүүлийн үед ноцтой зөрчигдөж, эцэг, эх, асран хамгаалагчдаас үр хүүхэддээ тавих анхаарал халамж дутсанаас хүүхэд сургууль завсардах, хараа хяналтгүй тэнэх, элдэв сөрөг нөлөөнд автах явдал өсч байна.

Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэрэг жил тутам нэмэгдэж зарим төрлийн гэмт хэрэг зохион байгуулалтын хэлбэртэй болж, онц хэргийгээр хүний амь нас хохироох, хулгай, дээрэм хийх, залилан мэхлэх, галдан шатаах зэрэг онц хүнд буюу хүнд гэмт хэргийг хүүхэд үйлдэх боллоо.

Хүүхэд ууж согтуурах, биеэ үнэлэх, хүүхдийг хүчирхийлэх явдал гарч байгаа нь сэтгэл түгшээж байна. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хүүхэд амь насаа алдах, бэртэж гэмтэн тахир дутуу болох нь олонтаа байна.

1994-1998 онд улсын хэмжээнд 6951 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон нь өмнөх 5 жилийнхээс 24,9 хувиар өссөний дотор тэдний үйлдсэн хулгайн хэрэг 28,8 хувиар, хүний амь нас бусниулсан хэрэг 22,2 хувиар, бусдын эд зүйлийг булаасан хэрэг 9,3 хувиар нэмэгдсэн байна. Энэ хугацаанд гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо 14,8 хувиар, эрүүл мэнд хохирох явдал 37,4 хувиар өссөн байна. 1998/1999 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 10 мянга гаруй хүүхэд сургууль завсарджээ.

Дурдсан байдлуудаас үзэхэд хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хугацаа алдалгүй эрчимжүүлж хүүхдийн эрх

ашгийг хамгаалах, хариуцлагын тогтолцоо буй болгох талаар шийдвэрлэвэл зохих асуудал цөөнгүй байна.

Хоёр.Хөтөлбөрийн зорилго

2.Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих явцад гарч буй ажилгүйдэл, ядуурал, ёс суртахууны доройтол, гэмт хэргийн өсөлт, сургууль завсардалт зэрэг нийгмийн сөрөг үзэгдлийг бууруулах үндсэн дээр хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, энэ чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, эцэг, эхчүүдийн гүйцэтгэх үүргийг өндөржүүлэх, тэдний үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад чиглэгдэнэ.

Гурав.Хөтөлбөрийн зорилт

3.Хүүхдийн эрх ашгийг хохироож байгаа явдалд судалгаа дүгнэлт хийж, урьдчилан сэргийлэх ажлын чиглэлийг үндэсний хүрээнд болон орон нутаг, анхан шатны нэгжид ялгавартайгаар нарийвчлан тодорхойлох.

4.Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан бусад эрх ашгийг хамгаалах ажилд төр, олон нийтийн зүгээс хяналтын тогтолцоо бий болгож бүх нийтийг татан оролцуулах, гэмт хэрэгт хүүхэд холбогдох явдлыг тодорхой хугацаанд үе шаттай бууруулах.

5.Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий болон тусгай, нэг бүрчилсэн арга хэмжээ зохион байгуулж хүүхдийн зонхилон үйлдэж буй хулгай, булаалт зэрэг тодорхой төрлийн гэмт хэргийн өсөлтийг багасгах, таслан зогсоох ажлыг бүх шатанд зохион байгуулах.

6.Хүүхдийг гэмт хэрэгт уруу татагчдыг цаг алдалгүй илрүүлэх, тэдэнтэй хийх тэмцлийг хүчтэй болгох асуудлыг боловсруулах.

7.Хүүхдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг



гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, ялангуяа гэр бүл, эцэг, эхийн хүч, анхаарлыг нэгтгэн зохион байгуулах.

Дөрөв.Хөтөлбөрийн зарчим

8.Энэхүү хөтөлбөр нь Үндсэн хууль бусад хууль, тогтоомжийн заалтуудыг биелүүлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүр жигд оролцох, энэ талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй этгээдэд төр, нийгмийн зүгээс хариуцлага хүлээлгэх зарчимд үндэслэгдэнэ.

9.Гэмт хэрэг үйлдсэн хүүхдэд гэм буруугийн хор нөлөө, нөхцөл шалтгааныг ойлгуулах, тэдэнд нийгмийн амьдралын танин мэдэхүйн төлөвшил олгох, дахин гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг орчин үеийн шаардлагад тохирсон арга хэлбэрээр бодитой зохион байгуулна.

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

10.Хөтөлбөрийг 2000-2005 онд 3 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат: 2000-2001 онд төв, орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж, сургалт, судалгаа, сурталчилгаа, мэдээлэл, арга зүйн ажлыг бүх түвшинд жигдрүүлнэ. Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлан тогтоох ажлыг төв, орон нутагт зохион байгуулна;

Хоёрдугаар үе шат: 2002-2003 онд хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргийн нөхцөл шалтгааныг судалсан дүн шинжилгээнд үндэслэн түүнийг арилгах, ялангуяа хүүхдийн зонхилон үйлдэж буй хулгай, танхайн гэмт хэргийг багасгах, таслан зогсооход чиглэсэн иж бүрэн арга хэмжээг улсын хэмжээнд авч хэрэгжүүлнэ;

Гуравдугаар үе шат: 2004-2005 онд хүүхдээс гэмт хэрэг үйлдэх явдлыг сааруулах, зарим төрлийн гэмт хэргийг таслан зогсоох зорилт

тавьж ажиллана.

Зургаа.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

11.Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг төр, засаг, хууль хяналт болон бусад байгууллага, олон нийт, ард иргэдийн анхаарлын төвд байлгаж, хүүхдийн эрүүл энх өсөн бойжих, сурч боловсрох, хүмүүжих нөхцөлийг бүрдүүлэх.

12.Төр, захиргаа, хууль хяналт, хүүхдийн болон боловсрол, эрүүлийг хамгаалах, нийгмийн халамжийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулж, нэгдсэн бодлоготой ажиллуулах, хүүхдээс гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцөлийг судалж түүнтэй тэмцэх аргачлал боловсруулан сурталчлах, гэмт хэргийн хор уршгийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байх.

13.Иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус бүх байгууллагаас хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, ёс суртахуун, хүмүүжлийн чиглэлээр ерөнхий урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон хүүхдийг гэмт хэрэг үйлдэх, давтан үйлдэхээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх.

14.Хүүхдийг хүнлэг болгон хүмүүжүүлэхэд чиглэсэн ажил, сургалтыг сургууль болон сургуулиас гадуур гэгээрэл, шинжлэх ухаан, соёлын байгууллагуудтай хамтран зохион байгуулах, шаардлагатай ном, сурах бичиг, гарын авлага, сурталчилгааны материал, кино, драм, зохиолыг нийтийн хүртээл болгох.

15.Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудлаар уулзалт, өдөрлөг, онол арга зүйн бага хурал, ярилцлага зэргийг хэсэгчилсэн болон бүсчилсэн байдлаар зохион байгуулж төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг оролцуулах.

16. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж бүр өөрийн онцлог болон бүрэн эрхийнхээ хүрээнд ажиллагчдынхаа хүүхдийн асуудлыг эрхэлсэн орон тооны буюу орон тооны бус ажилтан, ажлын хэсэг, зөвлөл байгуулан ажиллах.

17. Хүүхэд гэмт хэрэг үйлдэхгүй байх орчныг бүрдүүлэх үндэс болсон гэр бүлийг бэхжүүлэх, иргэд, эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, сургууль завсардах явдлыг багасгах талаар холбогдох арга хэмжээг авах.

18. Хүүхдийг гэмт хэрэг, ёс суртахууны доголдолд уруу татсан этгээдэд оногдуулах хариуцлагыг чангатгах, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар арга хэмжээ авах.

19. Хүүхэд сургууль завсардан тэнүүчилж, хөгжил, боловсролоор доголдон хүмүүжлийн сөрөг нөлөөнд автаж байгаа байдлыг төрийн болон төрийн бус байгууллагын хүчийг нэгтгэн судалсны үндсэн дээр түүнээс гарах арга замыг тодорхойлж ажиллах.

20. Хүүхдийн эрхийг хамгаалах, тэднийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бүх нийтийн ажил өрнүүлэх, хуримталсан туршлагыг дэмжин дэлгэрүүлэх, хөрөнгийн нэгдсэн эх үүсвэртэй болох, тэргүүний байгууллага, аж ахуйн нэгж, гэр бүл, иргэдийг урамшуулах.

Долоо. Удирдлага, зохион байгуулалт

21. Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын орон тооны бус зөвлөл удирдана /цаашид "Зөвлөл" гэх/. Зөвлөлийн ажиллах журмыг Хууль зүйн сайд батална.

22. Зөвлөл нь "Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг 2000-2005 онд хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэл"-ийн хүрээнд жил бүрийн ажлын төлөвлөгөө

гарган ажиллана.

23. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дэргэд тэдгээрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан 9-15 хүний бүрэлдэхүүнтэй Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх салбар зөвлөл ажиллана. Салбар зөвлөлийн ажиллах журмыг Зөвлөл батална.

24. Салбар зөвлөл нь ажлаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд тогтмол танилцуулан, уялдуулж ажиллана.

25. Салбар зөвлөл нь Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөр боловсруулан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулж ажиллана. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүрийн 1 дүгээр сард багтаан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлуулна.

26. Бүх шатны зөвлөл нь төрөөс хүүхдийн талаар хэрэгжүүлж буй бодлогыг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлж яам, агентлаг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, хамтран ажиллана.

27. Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага дараахь чиглэлээр ажиллана:

1. Хууль зүйн яам

- Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийг боловсронгуй болгох, энэ чиглэлийн хуулийг сурталчлах;

- Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж яам, агентлаг, төв болон орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг энэ ажилд жигд татан оролцуулах;



-Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн төрөл, шалтгаан, нөхцөл, тэдгээрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохиох ажлын талаар гарын авлага боловсруулж төв, орон нутагт ажиллаж байгаа зөвлөлүүдийг хангах;

-Хүүхдийн хүмүүжил, ёс суртахуунд харшаар нөлөөлөх садар самуун, хүчирхийлэл, аллага бүхий кино, дүрс бичлэг, ном зохиол, зураг, сонин хэвлэлийг хязгаарлан, хаах хүртэл арга хэмжээг авч хуульд заасан хариуцлага хүлээлгэх.

2. Гэгээрлийн яам

-Сургалт хүмүүжлийн ажлын нэгдлийг хангахад чиглэсэн иж бүрэн бодлого боловсруулж, энэ талаар эрх зүйн орчин бүрдүүлж биелэлтийг зохион байгуулах;

-Хүүхдийн сэтгэл зүй, насны онцлогийг харгалзан сургууль, цэцэрлэгийн хичээл, хүмүүжлийн ажлын хүрээнд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах судалгаа хийж, дүгнэлт гаргах, гэмт хэрэггүй сургууль, хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэх, энэ талаархи туршлагыг нь сурталчлан урамшуулах;

-Сургууль завсардах явдлыг гаргахгүй байх арга хэмжээг зохион байгуулах;

-Ерөнхий боловсролын сургуульд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн тусгай сургалт, дадлагын ажил, сурагчдын чөлөөт цагийг идэвхтэй өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах, сургууль-багш-эцэг, эх-хүүхдийн хамтын ажиллагааг хөгжүүлэх;

-Гэмт хэрэгт холбогдсон болон хохирсон хүүхдийг хүмүүжүүлэх буюу тэдэнд тусалж дэмжих талаар "Хүүхэд хүүхдийнхээ төлөө" ажил өрнүүлэх.

3. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам

-Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенци,

Хүүхдийн эсэн мэнд амьдрах нөхцөлийг хангах, хамгаалах, хөгжүүлэх тухай дэлхийн дээд хэмжээний уулзалтын Тунхаглалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын асуудалд онцгой анхаарч, хөдөлмөр эрхлүүлэх, халамжлах асуудлаархи бодлогыг нэгтгэн бусад яам, агентлаг, хууль хяналт, нутгийн захиргааны байгууллагуудтай хамтарч ажиллах;

-Хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнийг татан оролцуулах, хүүхдийг гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэхэд Хүүхдийн төлөө үндэсний төв, түүний харьяа болон орон нутаг дахь байгууллагуудын хүчийг чиглүүлж ажиллах;

-Хүүхэд бие бялдар, эрүүл мэндийн хувьд хохирох, архи тамхи болон мансууруулах бодис хэрэглэх зэрэг элдэв гаж нөлөөнөөс урьдчилан сэргийлэх ажлыг хүртээмжтэй арга хэлбэрээр зохиож үр дүнг тооцох;

-Хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийг нийгмийн хамгаалалд бүрэн хамруулах, сургуулийн хичээлийн хэрэгсэл, хувцас, бусад материаллаг туслалцаа үзүүлж байх.

4. Бусад яам, агентлаг, төрийн байгууллага

-Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар өөрийн төв аппарат, харьяа болон бодлогын хүрээний нийт байгууллага, аж ахуйн нэгжийн хэмжээнд хүүхдийн хүмүүжил, ёс суртахууны төлөвшилийг сайжруулах талаар жил бүр төлөвлөгөө гарган, сургалт сурталчилгаа явуулах, энэ ажлыг хариуцсан зөвлөл байгуулж ажиллуулах;

-Хүүхдийн эрх ашгийг хамгаалах ажлын төрөл, арга хэлбэрийг сайжруулж, албан тушаалтны хүлээх үүрэг хариуцлагыг тодотгож байгууллагынхаа дотоод журамд тусгах, үр хүүхдээ үлгэр жишээч хүмүүжүүлсэн ажилтан, албан хаагчдыг урамшуулах.

5.Хэвлэл мэдээллийн байгууллага

-Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдэд гэмт хэргийн хор уршиг болон түүнээс учирч болох сөрөг үр дагаврыг ойлгуулж, итгэл үнэмшил төрүүлэх, ирээдүйн хүсэл мөрөөдлийг бий болгоход нийтлэл нэвтрүүлгийн бодлогыг чиглүүлэх, Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн ажлын явц, цаашид хийх ажлын талаар нийтэд сурталчилж, мэдээлэх;

-Хүүхдээ гэмт хэрэгт өртүүлэхгүй байх талаар эцэг, эхчүүдэд зориулан цуврал сурталчилгааг тогтмол хийж байх.

6.Иргэн, гэр бүл, төрийн бус байгууллагын оролцоо

-Эцэг, эх, ах, эгч нь хүүхдийг ёс суртахуун, үзэл бодлын зөв төлөвшилтэй, энэрэнгүй сэтгэлтэй, харьцааны соёлтой болгон хүмүүжүүлэх;

-Хүүхдэд гэмт хэрэг үйлдэх нөхцөл бололцоо гаргахгүй байх зорилгоор гэр бүл, иргэд идэвхтэй оролцон үр хүүхдээ байнгын хараа хяналттай байлгаж, үнэнч шударга иргэн болгож хүмүүжүүлэх;

-Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар төрийн бус байгууллагын зүгээс жил бүр тодорхой ажил төлөвлөн хэрэгжүүлэх;

-Хүүхдийн төлөө ажилладаг төрийн бус байгууллагууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар байнга санал солилцож хамтран ажиллах, хурал, зөвлөлгөөн, уулзалт, семинар зохион байгуулж, сайн ажилласан байгууллага, хүмүүсийг шалгаруулж, дүгнэх, шаардлагатай бол хөрөнгө мөнгөний туслалцаа үзүүлж байх.

7.Цагдаагийн байгууллага

-Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий болон тусгай, нэг бүрчилсэн ажиллагааг зохион байгуулах, эдгээр ажлын

аргачлалыг боловсруулж нэвтрүүлэх, аймаг, нийслэл, дүүрэг, томоохон сумдад сургалт арга зүйн кабинет байгуулж сурталчлах;

-Хүүхдийн үйлдэж буй тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судлан, дүн шинжилгээ хийж мэдээлэх, эцэг, эх, хуульч, улс төр судлаач, сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйч, төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтдийг оролцуулан эрдэм шинжилгээний бага хурал, ярилцлага зохион байгуулж, тухайн гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар онол практикийн бага хурал зохион байгуулж санал дүгнэлт гаргах, үйл ажиллагааны аргачлал боловсруулж мөрдөх;

-Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн талаар мэдээлэл цуглуулан шалтгаан нөхцөлийг судалсны үндсэн дээр түүнтэй тэмцэх арга замыг тодорхойлох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээллийн нэгдсэн сүлжээ бий болгож, хүүхдийн дотор гэмт хэрэгтэй тэмцэх ажлын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх;

-Хүүхдийн эрх ашгийг хохироосон үйл ажиллагааг хориглох, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн заалтыг зөрчсөн этгээдэд заавал хариуцлага хүлээлгэх;

-Хараа хяналтгүй, гэр орноосоо дайжсан тэнэмэл хүүхдийн асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран судалгаа явуулж хүүхдийн хаяг тогтоох, шалган хуваарилах ажлын үр нөлөөг дээшлүүлэх;

-Хүүхдийн үйлдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөлийн судалгаанд үндэслэн хулгай, танхай зэрэг хүүхдийн зонхилон үйлддэг тодорхой төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулахад чиглэсэн ажил зохион байгуулах;

-Хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн үүсгэл санаачилгыг дэмжиж, ялангуяа өсвөрийн цагдаагийн бүлэг, эцэг, эхийн зөвлөл, хороог байгуулж ажиллуулах.

8.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар



-Хүүхдийн үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг судалж тэдгээрийг арилгах иж бүрэн арга хэмжээ төлөвлөн зохион байгуулж, өрх гэр, эцэг, эх, иргэдийн оролцоо туслалцааг сайжруулах, харьяа нутаг дэвсгэртээ байгаа аж ахуйн нэгж, байгууллагад /өмчийн хэлбэр харгалзахгүй/ энэ чиглэлээр үзлэг шалгалт явуулан дүгнэж байх;

-Албан байгууллага, аж ахуйн нэгж, сум, хороо, баг, байр, гудамж, талбайд хүүхдийн төлөө сайн дурын нөхөрлөл, эргүүл, харуул байгуулан ажиллуулах, хүүхдээс гэмт хэрэг үйлдэх боломж нөхцөлгүй эрүүл орчин буй болгоход чиглэсэн ажил зохион байгуулан, түүнд иргэд, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгууллагыг татан оролцуулж байх.

Найм.Хөтөлбөрийн санхүүжилт

28.Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан хөрөнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр санхүүжүүлнэ.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид жил бүр энэ асуудлыг тухайн орон нутгийн төлөвлөгөө, төсөвт тусган шийдвэрлэж байна.

29.Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажилд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тухайн жилийн улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн яам, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

30.Иргэд, аж ахуйн нэгж, олон улсын болон гадаад, дотоодын байгууллагын хандив, тусламж, бусад нөөц бололцоог ашиглан Хүүхдийн болон

түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх Зөвлөлүүдийн дэргэд сан байгуулж үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилд зарцуулна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулсан уг сангийн хөрөнгийг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийн дагуу зарцуулах бөгөөд өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Төсвийн болон хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын тайланг Зөвлөлийн дарга тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд жилд 2-оос доошгүй удаа танилцуулж байна.

Ес.Хөтөлбөрийн үр дүнгийн талаар

31.Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын үр дүнг тооцох аргачлал болон тайлангийн үзүүлэлтийг Зөвлөл боловсруулж гаргана. Дүгнэхдээ дараахь үзүүлэлтийг голлон үзнэ:

а/хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэрэг буурсан байдал, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах талаар зохиосон ажил;

б/төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүл, иргэдийн оролцоотой хэрэгжүүлсэн ерөнхий болон тусгай, нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг дээшлүүлсэн байдал, гэр бүлийг бэхжүүлэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн зохион байгуулалтын ажил, түүний үр дүн;

в/хараа хяналтгүй хүүхдийн нийгмийн хамгааллын талаар зохиосон ажлын явц, үр дүн;

г/сургууль завсардалтыг багасгахад чиглэсэн ажлын үр дүн;

д/хүүхдийн нас, биеийн онцлогт тохирсон ажлын байр бий болгосон байдал.



ХҮҮХДИЙН БОЛОН ТҮҮНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ 2000-2005 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛ

№	Хийх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа /оноор/					
			2000	2001	2002	2003	2004	2005
1	Нэг.Зохион байгуулалтын талаар Салбар ажиллах журмыг баталж орон нутагт салбар зөвлөлүүдийг байгуулж ажилд оруулах	Зөвлөл, аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	+	+				
2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар Зөвлөлөөс хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлэг, зурагт хуудас хэвлүүлэх, клип хийж сурталчилах зардлыг жил бүрийн төсөвт тооцон тусгах	Сангийн яам, Гэгээрлийн яам, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга	+	+	+	+	+	+
3	"Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын үр дүнг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд жил бүр нэгтгэн гаргаж, нийтэд мэдээлж байх	Бүх шатны зөвлөл	+	+	+	+	+	+
4	Хуульч, багш, эмч, сэтгүүлч, сэтгэл зүйч, улс төр судлаачийг оролцуулан хүүхдийн үйлдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцөл, түүнийг арилгах арга замын талаар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж зөвлөмж гаргах	Зөвлөл, Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гэгээрлийн яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, аймаг, нийслэлийн салбар зөвлөл		+		+		+
5	Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулж үр дүнд хүрч байгаа аймаг, нийслэл, сум, дүүргийн салбар зөвлөлийг шалгаруулах уралдаан зарлаж дүгнэх	Зөвлөл, аймаг, нийслэлийн зөвлөл		+		+		+

6	Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын тэргүүн туршлага, арга ажиллагааг сурталчилах, гэмт хэргийг багасгах арга замын тухай сэдэвт зохион бичлэгийн уралдаан зарлаж дүгнэх	Аймаг, нийслэл, сум, дүүргийн зөвлөл	+	+	+	+	+	+
7	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохиосон баг, хороо, сургууль, хүүхдийн байгууллагыг шалгаруулах уралдааныг 2 жилийн хугацаатай зарлаж дүгнэх	Зөвлөл, Хууль зүйн яам, Гэгээрлийн яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Монголын хүүхдийн төлөө үндэсний төв		+		+		+
8	Хараа хяналтгүй хүүхдүүдийн талаар судалгаа явуулж нийгмийн хамгаалалд хамааруулах асуудал боловсруулж шийдвэрлүүлэх	Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам	+	+	+	+	+	+
9	Сургууль завсардалтыг багасгахад чиглэсэн бодлого, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Гэгээрлийн яам	+	+	+	+	+	+
10	Хүүхдээс гэмт хэрэгт холбогдож байгаа шалтгаан нөхцөлд дүгнэлт хийж урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах аргачилал боловсруулж хэрэгжүүлэх	Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар	+		+		+	
11	Ядуурал, ажилгүйдлээс болж хүүхэд сургууль завсардах, гэмт хэрэгт холбогдож байгаа явдлыг бууруулах, сааруулахад чиглэсэн арга хэмжээ авах	Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Ядуурлыг бууруулах сан, бүх шатны Засаг дарга	+	+	+	+	+	+
12	Хараа хяналтгүй хүүхдийг асарч сувилан, боловсрол мэргэжил олгох, хүмүүжүүлэх цогцолбор сургууль, төв шинээр байгуулах, одоо ажиллаж буй сургууль төвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг боловсруулах	Гэгээрлийн яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар		+	+	+	+	+

5	Эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн сургалт, семинар, уулзалт ярилцлага, онол арга зүйн бага хурлаар хүүхдийн хүмүүжил, уламжлалт ёс заншлыг сурган төлөвшүүлэх зэрэг сэдэвт асуудлуудыг хэлэлцэж зөвлөмж гаргах.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн зөвлөл, ахмадын болон залуучууд, хүүхдийн байгууллага	+	+	+	+	+
6	Хүүхдийн эрх ашгийг хамгаалах зөв төлөвшил, мэдлэг олгох зайны буюу эчнээ сургалт, теле хичээл явуулах ажлыг зохион байгуулах	Зөвлөлүүд, Гэгээрлийн яам, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар, бүх шатны Засаг дарга	+	+	+	+	+
7	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн заалтыг нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг жил бүр тооцож, дүгнэх	Зөвлөл, Хууль зүйн яам, орон нутгийн зөвлөлүүд	+	+	+	+	+
8	Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд үйл ажиллагааныхаа хүрээнд хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил зохиож үр дүнг тооцдог журам боловсруулах	Бүх шатны зөвлөл	+	+	+	+	+
9	Хорих ял шийтгэгдсэн, ял хойшлогдсон хүүхдүүдэд хүмүүжлийн хяналт тавьж урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй зохиож тэдэнд хүмүүжил олгох	Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар	+	+	+	+	+
10	Хороо, баг бүрт хүүхдийг хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ярилцлага зохиох, иргэдийн санал асуулга явуулах, иргэдийг эргүүл, жижүүрт гаргаж хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах	Салбар зөвлөл, сум,баг, хорооны Засаг дарга, цагдаагийн хэсгийн байцаагч нар	+	+	+	+	+
11	Гэмт хэргийн хор уршгийг жигших, ахмад үеийнхний хөдөлмөрч, хүнлэг зан заншлыг хүүхдэд өвлүүлэх зэрэг ажлыг хүүхдийн өөрсдийнх нь байгууллагын хүчээр зохион байгуулах	Гэгээрлийн яам, Монголын хүүхдийн төлөө үндэсний төв, МАХолбоо, МЗХолбоо	+	+	+	+	+

Засгийн Газрын 1999 оны 229 дүгээр тогтоолын 3 дугаар засралт

ХҮҮХДИЙН БОЛОН ТҮҮНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ХЯНАЛТТАВИХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга	-Засгийн газрын	цах бодлого, зохицуулалтын албаны дарга;
Хэрэг эрхлэх газрын дарга		
Орлогч дарга	-Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга	-Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга;
дарга	-Улсын нийгмийн халамжийн газрын	-Улсын ерөнхий прокурорын туслах (өөртэй нь тохиролцсоноор);
уширд-	Гишүүд: -Гэгээрлийн яамны Стратегийн лага, төлөвлөлтийн газрын дарга;	-Улсын дээд шүүхийн Судалгааны төвийн захирал (өөртэй нь тохиролцсоноор);
	-Хууль зүйн яамны Гэмт хэргтэй тэм-	-Төрийн өмчийн хорооны Төрийн



байгууллагуудын хангамж,эд хөрөнгийн бүртгэлийн газрын дарга;

-Монголын хүүхдийн төлөө үндэсний төвийн дарга;

-Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх газрын дарга;

-Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөрийн газрын дарга;

-Монголын залуучуудын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга (өөртэй нь тохиролцсоноор)

Нийслэлийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн газрын дарга;

-Хүүхдийн эрхийн төвийн гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-Хүүхдийн эрхийн төвийн тэргүүн (тохиролцсоноор);

-Монгол телевизийн "Боловсрол" студийн захирал;

-Хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн захирал;

-Монголын радиогийн сургалт,танин мэдэхүйн албаны дарга;

-Нийслэлийн "Улаанбаатар" радио станцын дарга.

Нарийн бичгийн дарга
-Эрүүгийн цагдаагийн газрын Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга.

— МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2000 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

"Улсын сайн малчин" тэмдгийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

нь:

1."Улсын сайн малчин" тэмдгийн тодорхойлолтыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын

19.	Улсын сайн малчин	Хөдөө аж
-----	-------------------	----------

ахуй, үйлдвэрийн сайд] гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙЛДВЭРИЙН САЙД

Ч.СОДНОМЦЭРЭН

Засгийн газрын 2000 оны 1 дүгээр тогтоолын хавсралт

"УЛСЫН САЙН МАЛЧИН" ТЭМДГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Уг тэмдэг нь 2 хэсгээс бүрдэнэ. Эх биеийн хэсэг нь 40 мм-ийн голч бүхий хэмжээтэй дугуй байх бөгөөд түүний дотор талын бага дугуй нь цэнхэр ногоондуу дэвсгэр дээр соёмбыг товгордуу байдлаар шар өнгөөр дүрсэлсэн байна. Соёмбын хоёр талаар "Улсын сайн малчин" гэж монгол бичгээр шар өнгөөр бичнэ. Их дугуйд 5 хошуу малын толгойн дүрсийг хүрэн улаан дэвсгэр дээр шар өнгөөр гаргасан, бусад

хэсэг нь цагаан өнгөтэй байна.Зүүлтийн хэсэг нь 30 мм урт, 15 мм өргөн, доод талдаа гурвалжилсан хэсэгтэй, үүний голын их өргөн 5 мм хэмжээтэй бөгөөд дундаа хөх, 2 тал нь улаан өнгө (төрийн далбааны)—тэй байна. Тэмдгийн зузаан нь 2 мм байна. Зүүлт нь сүлбүүр зүү мэт байна.

Тэмдгийн тухайлсан зохиомжийг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайд батална.

— МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2000 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 2

Улаанбаатар хот

Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасныг үндэслэн

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: 1."Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер,



ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Ардын армийн генерал, офицер, улирагчдад удаан жил ажилласны нэмэгдэл олгох тухай" Сайд нарын Зөвлөлийн 1978 оны 12 дугаар

сарын 13-ны өдрийн 419 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Ш.ТҮВДЭНДОРЖ

Засгийн газрын 2000 оны 2 дугаар тогтоолын хавсралт

Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам

1.Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн тусгай алба хаасан хугацаа /жилээр/	Төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/
5-7	5
8-10	8
11-14	12
15-19	15
20-24	20
25-30	25
31 ба түүнээс дээш	30

хэрэг байна.

3.Төрийн тусгай алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулан тооцно:

а/төрийн тусгай албанд ажилласан;

б/төрийн тусгай албанд ажиллах хугацаандаа байгууллагын бодлогоор дотоод, гадаадын академи, дээд, тусгай сургууль, мэргэжил дээшлүүлэх дамжаа, адъюнктур, магистрантур, докторантурт суралцсан;

в/төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсний, амаржсаны болон өвчний учир чөлөөтэй байсан.

2.Төрийн албанд ажилласан хугацааг тогтоох үндсэн баримт нь албан хаагчийн хувийн

4.Төрийн захиргааны байгууллагад тушаалаар ажиллаж буй офицер, ахлагч нар энэ журамд хамрагдана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 6

Улаанбаатар хот

Төсөв захиран зарцуулах эрхийн тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

"Улсын төвлөрсөн төсвийг ханган биелүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 5 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын "1.Зэвсэгт хүчний ерөнхий штаб, 2.Хилийн цэргийг удирдах газар" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

1.Батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхийг Батлан хамгаалах яаманд олгосугай.

2.Эрхэлсэн хүрээний агентлагууддаа хуваарилан олгосон төсвийн захиран зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндоржд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Ш.ТҮВДЭНДОРЖ

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ



— МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2000 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 8

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Болзлын шаардлага хангаж, өндөр амжилт гаргасан:

-Завхан аймгийн Дөрвөлжин сумын Онц багийн малчин Боожийн НАДМИД;

-Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөнөг багийн малчин Бямбадоржийн ЛУВСАНГОНЧИГ;

-Говь-алтай аймгийн Халиун сумын Олон-булаг багийн малчин Нямхүүгийн ДАВАА;

-Төв аймгийн Өндөрширээт сумын 1 дүгээр багийн малчин Жамцын ДОНТОР;

-Сэлэнгэ аймгийн Баянгол сумын 1 дүгээр багийн малчин Батын ЛХАГВАСҮРЭН;

-Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Хонгио багийн малчин Намдагийн СҮХБААТАР;

-Өвөрхангай аймгийн Бүрд сумын 3 дугаар багийн малчин Батнасангийн ЛУВСАНЖАМБАА;
-Ховд аймгийн Чандмань сумын Тахилт багийн

“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон” шалгаруулах тухай

малчин Цэндийн БЯМБАА;

-Завхан аймгийн Сантмаргац сумын Баян-нуур багийн малчин Шархүүгийн ЧУЛУУН;

-Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын 3 дугаар багийн малчин Чулуунбаатарын ГАНБААТАР нарыг “УЛСЫН САЙН МАЛЧИН”-аар.

-Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын Д.Насанжаргал захиралтай “НОМУН ХАН” ХХК-ийг “УЛСЫН ТЭРГҮҮНИЙ ТАРИАЛАНЧ ХАМТ ОЛОН”-оор тус тус шалгаруулсугай.

2. “Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”-д олгох тэмдэг, үнэмлэх, дурсгалын зүйлийн үнэд зориулж 3 сая 850 /гурван сая найман зуун тавин мянга/ мянган төгрөгийг улсын төсвөөс гаргахыг Сангийн сайд Я.Очирсүхэд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р. АМАРЖАРГАЛ

ХӨДӨӨ АЖ АХУЙ ҮЙЛДВЭРИЙН САЙД Ч.СОДНОМЦЭРЭН

— МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2000 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 9

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Монгол Улсын иргэний паспортыг иргэний үнэмлэхээр солихдоо 2000 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө 55 ба түүнээс дээш нас хүрсэн эмэгтэй, 60 ба түүнээс дээш нас хүрсэн эрэгтэй Монгол Улсын иргэнд иргэний үнэмлэхийг нэг удаа төлбөргүй олгохыг Хууль зүйн сайд Д.Ганболд,

Иргэний үнэмлэх төлбөргүй олгох тухай

Сангийн сайд Я.Очирсүх нарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Р. АМАРЖАРГАЛ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД Д. ГАНБОЛД

САНГИЙН САЙД Я. ОЧИРСҮХ

— МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ —

2000 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн тухай хуулийн биелэлтэд 1999 оны эцсээр улс орон даяар явуулсан Ерөнхий сайдын үзлэг, шалгалтад нийт аймаг, нийслэл, бүх сүм, дүүрэг, 6451 аж ахуйн нэгж, байгууллага, 211,0

Хуулийн биелэлтийг зохион байгуулж хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай

мянган ажилчин, албан хаагч (ажилтан) хамрагдсан байна. Түүнчлэн үзлэг, шалгалтын явцыг 9 яам, 28 агентлаг, нийслэл, 4 аймаг, 9 дүүрэг тэдгээрийн харьяа 32 байгууллагад Засгийн газраас давхар



шалгасан байна. Энэхүү ажлын хүрээнд төрийн бус судалгааны байгууллагаас "Ажилтанд хөдөлмөрийн хууль хэрхэн үйлчилж байна вэ?" сэдвээр 34 асуулт бүхий анкетын судалгааг нийслэл, 4 аймгийн 5000 гаруй ажилтныг хамруулан авч, дүнг нэгтгэн дүгнэлт хийжээ.

Үзлэг, шалгалт болон судалгааны дүнгээс үзэхэд нийт аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар орон нутгийнхаа хэмжээнд Хөдөлмөрийн тухай хуулийг мэдээлж, таниулах, семинар, ярилцлага зохиох, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн дотоод журам, гэрээг шинэчлэх, хамтын гэрээг байгуулах зэргээр уг хуулийг хэрэгжүүлэх талаар зарим ажил зохиож аятай эхлэл тавьсан байна.

Булган, Өвөрхангай, Сүхбаатар, Дархан-уул, Орхон аймгийн Засаг дарга, тэдгээрийн Тамгын газар, Багануур, Баянгол, Баянзүрх дүүрэг, Батлан хамгаалах яам үзлэг, шалгалтыг үр дүнтэй зохион байгуулсны дээр Ерөнхий сайдын үзлэг, шалгалтыг угтаж хууль сурталчлах, сургалт зохион байгуулах ажил идэвхжсэн байна.

Гэвч Хөдөлмөрийн тухай хуулийг аж ахуйн нэгж, байгууллага, ажилтан нэг бүрийн хөдөлмөрийн харилцаа, өдөр тутмын үйл ажиллагааны үндсэн журам болгон хэрэгжүүлэх талаар ажил олгогчдын санаачилга, чармайлт жигд бус, нэлээд газарт уг ажилд хойрго хандаж байгаа нь үзлэг, шалгалтаар илэрсэн байна. Аж ахуйн нэгж, байгууллагын 62,7 хувь нь хамтын гэрээг, 27,8 хувь нь хөдөлмөрийн гэрээг, 51 хувь нь хөдөлмөрийн дотоод журмаа хуульд нийцүүлэн шинэчлээгүй хуулийн заалтыг зөрчиж байна.

Түүнчлэн ажилтныг илүү цагаар ажиллуулж хөлсийг нь өгөхгүй байх, ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл олгохгүй байх зэргээр хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг зөрчих, дан ганц ажил олгогчийн болзлыг гэрээний нөхцөл болгож, ажилтны хүсэлтийг үл харгалзан ашиг сонирхлыг нь хохироох явдал гарсаар байхад хуулийн биелэлтийг зохион байгуулж хангуулах, хяналт тавих эрх бүхий байгууллагуудаас түүнтэй хийх тэмцэл сул байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн биелэлтэд хийсэн үзлэг, шалгалт нь удирдамжийн дагуу явагдаж ажил хэргийн бодит байдлыг үндэслэлтэй тодорхойлж, хууль биелүүлэх ажилд бүх нийтийн анхаарлыг төвлөрүүлэхэд чухал нөлөөтэй боллоо гэж үзээд Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөлмөрийн тухай хууль түүнчлэн Төрийн албаны тухай болон Компанийн тухай хуулийн холбогдох заалтын биелэлтэд хийсэн үзлэг, шалгалтын дүнг үндэслэн хуулийн биелэлтийг хангуулах зорилгоор Хууль зүйн сайд Д.Ганболд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Батбаяр нарт даалгах нь:

а/Монгол Улсын хууль, Засгийн газрын шийдвэрийг албан ёсоор хүлээн авах, байгууллага, албан тушаалтан болон хүн амд мэдээлэх, хүргэх, биелэлтийг нь зохион байгуулах, дүгнэх ажлын аргачлал, журмыг нарийвчлан боловсруулж, Засгийн газрын хуралдаанд энэ оны I улиралд багтаан оруулсугай;

б/Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрт заасныг үндэслэн хуулийн биелэлтийг зохион байгуулах, эрх зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий хуулийн албыг яамд, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газарт бэхжүүлэх асуудлыг боловсруулан Засгийн газарт танилцуулахын хамт хууль зүйн судалгаа, сурталчилгаа, албан бус сургалтыг мэргэшсэн төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх ажлыг жил бүрийн төсөв, төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байсугай;

в/Хууль зүйн яамны хууль, тогтоомжийн цахим санг баяжуулж, бүх яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай нэгдсэн сүлжээнд оруулах асуудлыг судалж шийдвэрлэсүгэй;

г/Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хангахтай холбогдсон хөтөлбөр боловсруулж, энэ оны эхний хагас жилд багтаан төрийн байгууллагуудад хэрэгжүүлж эхлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авсугай;



д/Хууль зүйн яамнаас эрхлэн гаргаж байсан "Хууль зүйн мэдээлэл" сэтгүүлийг "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн хавсралт болгон тогтмол гаргах асуудлыг судалж шийдвэрлэсүгэй.

2.Хуулийн биелэлтийг зохион байгуулж хангуулахтай холбогдсон сургалт, сурталчилгаа, хяналт шалгалтыг зохион байгуулах зардлыг санхүүжүүлэх асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэж байхыг Сангийн сайд Я.Очирсүхэд даалгасугай.

3.Хөдөлмөрийн тухай хуулийн биелэлтийг эрчимжүүлж, хөдөлмөрийн харилцаанд хуулийн заалтыг бүрэн хэвшүүлэх зорилгоор Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонинд даалгах нь:

а/Хөдөлмөрийн тухай хуулийн биелэлтэд тавих төрийн захиргааны хяналтыг сайжруулах арга хэмжээ авсугай;

б/Хөдөлмөрийн тухай хуулийн зарим асуудлаар мэдээлэл, шинжилгээ, судалгаа, үнэлгээ хийх ажлыг төрийн бус байгууллагуудаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх асуудлыг боловсруулан, энэ оны эхний хагас жилд туршилтын журмаар хэрэгжүүлсүгэй;

в/Хөдөлмөрийн нөхцөлийг шинжлэх лабораторийг шинэчлэн тоноглох буюу нэмж байгуулах, мэргэшсэн боловсон хүчнээр хангах, энэ ажилд орон тооны бус шинжилгээний экспертийг оролцуулах асуудлыг Сангийн яамтай хамтарч энэ

оны эхний хагас жилд шийдвэрлэсүгэй; г/хөдөлмөрийн дотоод журам болон хөдөлмөрийн гэрээний нөхцөлийг хуулийн дагуу тодорхойлох, түүнд ажилтны санаа бодол зохих ёсоор тусгагдаж байх нөхцөлийг бүрдүүлсэн аргачлал, загвар боловсруулж, практикт нэвтрүүлэх арга хэмжээ авсугай.

4.Сайд, агентлагийн болон бүх шатны Засаг дарга нарт даалгах нь:

а/Хөдөлмөрийн тухай хуулийн үзлэг, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн хамт аливаа хуулийн биелэлтийг байнгын ажил болгон Засгийн газрын нэрийн өмнөөс зохион байгуулж байсугай;

б/өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, албан байгууллагууд Хөдөлмөрийн тухай хуулийг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хамтын гэрээ, хэлэлцээрийг байгуулах, бүртгэх асуудлыг тодорхой ажилтанд албан ёсоор хариуцуулан гүйцэтгүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Д.ГАНБОЛД

ЭРҮҮЛ МЭНД НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

С.СОНИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2000 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1.Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүх, Прокурор, Улсын аюулгүй байдлыг хангах газар, цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр биелүүлэх, гал түймэртэй тэмцэх байгууллагын албан хаагчид, тэдний гэр бүл,

чөлөөнд байгаа ахмадуудад үйлчлэх үүрэг бүхий "Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг"-ийг Хилийн цэргийн удирдах газрын харьяа хүн эмнэлгийн боловсон хүчин, материаллаг баазад тулгуурлан байгуулж ажиллуулсугай.

2.Хүн эмнэлгийн материаллаг бааз, төсвийг нийт боловсон хүчний хамт тус эмнэлэгт шилжүүлэх, цаашид өргөтгөх ажил зохион



байгуулахыг Хууль зүйн сайд Д.Ганболд, Сангийн сайд Я.Очирсүх, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайд С.Сонин, Батлан хамгаалахын сайд Ш.Түвдэндорж нарт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Цэргийн зарим байгууллагуудын зохион байгуулалтын тухай" Засгийн газрын 1994 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн 88 дугаар тогтоолын 3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Р. АМАРЖАРГАЛ

ХУУЛЬ ЗҮЙН САЙД

Д.ГАНБОЛД

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД

Ш.ТҮВДЭНДОРЖ

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

С.СОНИН

Монгол Улсын Засгийн газрын тогтоол

2000 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын зарим байгууллагын санхүүжилтийн тухай

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

С.Сонинд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Р.АМАРЖАРГАЛ

САНГИЙН САЙД

Я.ОЧИРСҮХ

ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД

С.СОНИН

Засгийн Газрын 2000 оны 14 дүгээр тогтоолын хаасралт

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВӨӨС САНХҮҮЖДЭГ ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

Нэг. Эмчилгээ, үйлчилгээний байгууллагууд

1. Улсын клиникийн төв эмнэлэг
2. Клиникийн нэгдсэн П эмнэлэг
3. П.Н.Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлэг
4. Халдвартын клиникийн эмнэлэг
5. Сүрьеэгийн клиникийн эмнэлэг
6. Гэмтэл согог, сэргээн засалтын клиникийн эмнэлэг
7. Сэтгэцийн эмгэгийн клиникийн эмнэлэг
8. Хавдар судлалын төв
9. Эх нялхсын эрдэм шинжилгээний төв
10. Сүрьеэгийн үндэсний төв
11. Халдварт өвчин судлалын төв
12. Арьсны өвчин судлалын төв
13. Сэтгэцийн эмгэг, наркологийн төв
14. Эмгэг судлал, шүүх эмнэлгийн төв
15. Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах төв
16. Цусны төв
17. Хилийн боомтуудын Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын товчоо, салбар
18. Оргил рашаан сувилал
19. Аржанчивлан дахь рашаан сувилал
20. Хөдөлмөр эмчилгээний газар
21. Нялхсын клиник сувилал

22. Эрүүл мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв

Хоёр. Агентлагууд

23. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын алба
24. Эм, биобэлдмэл эмчилгээний чанарын хяналтын алба
25. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын алба
26. Улсын нийгмийн халамжийн газар

Гурав. Хөдөлмөр, нийгэм хамгааллын байгууллагууд

27. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төв

Дөрөв. Салбарын хөрөнгө оруулалтын зардал

28. Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтын зардал
29. Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөрийн зардал

Тав. Бусад арга хэмжээ

30. Эрүүл мэндийн төвлөрсөн арга хэмжээний зардал



МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙДЫН ТУШААЛ

2000 оны 1 дүгээр сарын 7-ны өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

Журам, гэрчилгээний маягт батлах тухай

Ойн тухай хуулийн 22,26,27,28 дугаар зүйлийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор **ТУШААХ** нь:

1. "Модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгох, хэрэглэх журам"-ыг 1 дүгээр, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээний загварыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Байгаль орчныг хамгаалах албаны дарга Ц. Шийрэвдамбад даалгах нь,

а) Гарал үүслийн гэрчилгээг 2000 онд

хэрэглээний зориулалтаар бэлтгэсэн нарсyг худалдах, тээвэрлэх үйл ажиллагаанд туршилтын журмаар хэрэглэх, хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг орон нутгийн мэргэжлийн хяналтын алба, холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулах:

б) Гарал үүслийн гэрчилгээг хэвлэхэд шаардагдах нэг сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Байгаль хамгаалах сангаас гаргах.

САЙД

С.МЭНДСАЙХАН

Байгаль орчны сайдын 2000 оны 5 дугар тушаалын 1 дүгээр хавсралт

Модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгох, хэрэглэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журмыг модон түүхий эдийг бэлтгэх, боловсруулах, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагаанд хяналт тавихад дагаж мөрдөнө.

1.2 Журмын зорилго нь мод бэлтгэх, боловсруулах борлуулах, тээвэрлэх ажил, үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, хууль бусаар мод бэлтгэх, тээвэрлэх үйл ажиллагааг таслан зогсооход оршино.

Хоёр. Гарал үүслийн гэрчилгээ олгох

2.1 Тухайн жилд тогтоож өгсөн мод бэлтгэх дээд хэмжээнд багтаан зохих журмын дагуу бэлтгэсэн модон түүхий эдэд гарал үүслийн гэрчилгээ / цаашид "гэрчилгээ" гэх/ олгоно.

2.2 Мод бэлтгэгч нь бэлтгэсэн мод түүхий эдийг бусад худалдах, өөр газарт тээвэрлэхдээ гарал үүслийн гэрчилгээг бичиж худалдан авагч болон тээвэрлэгчид өгнө.

2.3 Модон түүхий эдийг худалдан авагч болон тээвэрлэгч нь өөр аймаг, сум болон нийслэлийн нутаг дэвсгэрт тээвэрлэн хүргэх, борлуулах тохиолдолд бүрт гэрчилгээг авч явах үүрэгтэй.

Гурав. Гэрчилгээ, түүнд тавих хяналт

3.1 Гарал үүслийн гэрчилгээ нь батлагдсан загвартай байх бөгөөд үүнийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага / цаашид төв байгууллага гэх/ батална.

3.2 Гэрчилгээ нь төв байгууллагаас бүртгэж индексжүүлсэн сери, дугаартай байна.

3.3 Гэрчилгээг нэгдсэн журмаар хэвлүүлэх, орон нутагт хүргүүлэх, бүртгэх, зэрэг ажлыг байгаль орчныг хамгаалах алба ерөнхийд нь зохион байгуулна. 3.4 Гэрчилгээг олгож, түүний хэрэглэж

байгаа үйл ажиллагаанд байгаль орчны хяналтын төв, орон нутгийн байгууллага, төмөр зам, авто тээвэр болон цагдаагийн байгууллага хяналт тавина.

3.5 Гэрчилгээний хүчинтэй байх хугацааг гэрчилгээ олгогч, авагч нар харилцан тохиролцож тогтооно. Хүчинтэй байх дээд хугацаа нь 1 жилээс илүүгүй байвал зохино.

3.6 Гэрчилгээнд заагдсан модон түүхий эд нь зохих газраа тээвэрлэгдсэн, зориулалтын дагуу хэрэглэгдсэн, боловсруулаж эцсийн бүтээгдэхүүн болсон тохиолдолд хүчинтэй байх хугацааг харгалзахгүйгээр байгаль орчны хяналтын улсын байцаагч хааж, шалгасан тухай тэмдэглэлд бичнэ.

3.7 Гэрчилгээг засварлах, хувилж олшруулахыг хориглоно.

3.8 Үрэгдүүлсэн тохиолдолд анх олгосон аж ахуйн нэгж, байгууллагаас дахин авна.

3.9 Гэрчилгээгүй модон түүхий эдийг тээвэрлэсэн, худалдан авсан, борлуулсан этгээдэд Монгол улсын ойн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв. Бусад

4.1 Өөр аймаг сумын нутгаас худалдан авсан, тээвэрлэн авчирсан гуалин, зүсмэл материалыг шууд болон дахин боловсруулалт хийж худалдаалах тохиолдолд өмнөх гэрчилгээг үндэс болгон орон нутагт сумын Засаг дарга, Улаанбаатар хотод Байгаль орчныг хамгаалах алба шинээр гэрчилгээ олгож болно.

4.2 Аймаг, нийслэлийн Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч нар өөрийн нутагт аж ахуйн нэгж, байгууллагад олгосон, хянаж бүртгэсэн гэрчилгээний мэдээ, тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор Байгаль орчныг хамгаалах албанд ирүүлнэ.



Байгаль орчны сайдын 2000 оны
5 дугаар тушаалын 2 дугаар хэвсрэлт

Модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ

Сери . . . Дугаар . . .

Аймаг _____ сум _____
Мод бэлтгэгчийн нэр _____

Аж ахуйн нэгж байгууллагын гэрчилгээний дугаар, хаяг: _____

Мод бэлтгэх эрхийн бичгийн дугаар: _____

Модны нэр, төрөл: _____

Мод бэлтгэсэн газрын нэр: _____

Түүхий эдийн нэр, төрөл: _____

Модны хэмжээ (М²), тоо ширхэг _____

Худалдан авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр _____

Хаяг: _____

Тээвэрлэн хүргэх газрын нэр: _____

Тээврийн хэрэгслийн төрөл: _____ дугаар _____

Олгосон он . . . сар . . . өдөр

Хүчинтэй хугацаа . . . сар

Олгосон

/тэмдэг/

(Гэрчилгээ олгогчийн овог нэр, гарын үсэг)

Хянасан: Байгаль орчны хяналтын улсын байцаагч

(тэмдэг)

(овог нэр, гарын үсэг)

Үлдэх хувь

Гэрчилгээний сери . . . дугаар . . .

Гэрчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг: _____

Мод бэлтгэсэн газрын нэр: _____

Түүхий эдийн нэр, төрөл: _____

Модны хэмжээ (М²), тоо ширхэг: _____

Тээвэрлэн хүргэх газар: _____

Тээврийн хэрэгслийн төрөл _____ дугаар _____

Олгосон он сар өдөр Хүчинтэй хугацаа

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12
Төрийн ордон

329612
Индекс 14503

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэлтэх үйлдвэрт хэвлэв.

329487